




## МОНГОЛ ХӨӨМИЙН УРЛАГИЙГ ХӨГЖМИЙН БОЛОВСРОЛЫН ҮҮДНЭЭС СУДЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

<sup>a</sup>Бүргэд  
“БНХАУ, ӨМӨЗО, магистр

Холбоо барих зохиогч: burigedebaatar@gmail.com 

Хүлээн авсан: 2023.11.25

Хянагдсан: 2023.12.11

Зөвшөөрсөн: 2023.12.22

### Хураангуй

“Хөөмэй” буюу хөөмийлөх гэдэг нь усны урсгал, салхины амьсгал, уулсын цуурай, аянгын нүргээн, шувуудын жиргээ гэх мэт байгалийн дуу авиаг даган дуурайхаас үүссэн хөгжсөн бөгөөд эрт дээр үеэс өвөг дээдсээс уламжлагдан ирсэн өвөрмөц үндэсний язгуур урлаг юм. Энэ нь янз бүрийн дуу хоолой, хэл, уруулыг байрлуулах янз бүрийн аргуудыг хослуулан, өгүүлэх эрхтэний тусламжтайгаар хэд хэдэн дуу авиаг нэгэн зэрэг гаргах боломжийг олгодог дууны техникээр тодорхойлогддог онцлогтой. Хөөмэйг Монголын баруун тал Алтайн нурууны сав газар, Ховдын нутгаас гаралтай хэмээн үздэг.

### Түлхүүр үг

Өгүүлэх эрхтэнтэй шүтэлцэх урлаг, хөөмийн сургалт, амьсгалын тавил

### Удиртгал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 тоот “Монгол хөөмийн урлагийг хөгжүүлэх тухай” зарлигт: “Монголын ард түмний утга соёлын өвийн нэгэн төрөл болсон хөөмийлөх урлаг нь эртний өвөг дээдсийн дунд үүсч бий болсныг Монголчууд эдүгээ хүртэл өвлөн уламжилсаар ирсэн түүхэн гавьяатайг тэмдэглэж, давхац хөгөөр илэрхийлэгдсэн гайхамшиг болох уянгын хөөмий, хархираа хөөмий тэдгээрийн өвөрмөц дэг жаяг, арга маягийг сурч эзэмших, судалж хөгжүүлэх...” асуудлыг онцлон тусгасан нь хөөмийн урлагийг эзэмшүүлэх, өвлөх, сургах, судлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны нэгэн үндэслэл болох юм.

Үүнээс үзэхэд хөөмийн урлагийг судлах, сурах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, уламжлуулах нь зайлшгүй чухал бөгөөд харин үүнийг ямар зорилго, агуулга, арга замаар хэрэгжүүлэх вэ гэдэг нь судалгааны тулгамдсан асуудал юм.

Хөөмийг албан болон албан бус сургалтын хэлбэрээр сурах боломжтой бөгөөд албан бус сургалтын гол хэлбэр нь хөөмийн ардын авьяас билигтнүүд үеэс үед үр

хойчдоо гэрийн сургалтаар заан сургаж, өвлүүлж ирсэн байдаг.

Эндээс хөөмийг явцуу хүрээнд, дур сонирхлоороо цөөн хүн эзэмшиж ирсэн тал ажиглагдаж байна. Харин хоёр дахь хэлбэр буюу албан ёсны сургалтаар сурч эзэмших боломжийг өнөөгийн сургалтад хэрэгжүүлэх нь түгээмэл хандлагатай болж байна.

“1992 оноос МУИС-д Ардын урлаг судлалын анги нээснээр хөөмийг бакалаврын түвшинд судлах судлаачдыг бэлтгэж” (Хэрлэн, 2010, х.2) 2004 оноос СУИС-ийн дэргэд мэргэжлийн хөөмийчдийг бэлтгэх сургалт эхэлж, “Монгол хөөмий” чиглэлээр 70 бакалавр, 20 магистр бэлтгэдсэн байна. 2022 онд СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн “Үндэсний язгуур урлаг” бакалаврын хөтөлбөр БМИУЗ-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд амжилттай орж, магадлан итгэмжлэгдсэн зэргээс үзвэл албан сургалтын хэлбэрээр хөөмийн урлаг өргөжин хөгжих хандлагатай байна.

Орчин үед хөөмий сонирхогчдын хүрээ Монгол улсад төдийгүй хилийн чанадад ОХУ, БНХАУ, Япон, ХБНГУ, Франц зэрэг улс орнуудад өргөжин тэлснээр албан сургалтаар хөөмийг сурч эзэмших хүмүүсийн тоо өсөн нэмэгдэж байна.

Хөөмийн урлагийг заах, суралцах нь нэлээд төвөгтэй, цаг хугацаа их шаарддаг, хүчин чармайлт, тэвчээр, хөдөлмөрөөс ихээхэн хамаардаг хэмээн судлаачид болон хөөмийчид дурдсан нь олонтаа. Иймд тодорхой хугацаанд сургалтын агуулга, арга зүйг оновчтой тогтоон хэрэгжүүлснээр үр дүнд хүрэх боломж байна.

Бид энэхүү өгүүлэлд Монгол хөөмийг хөгжмийн боловсролын үүднээс судлах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохыг оролдлоо.

## Үндсэн хэсэг 1. Хөөмийн урлагийн онцлог, төрөл ангилал

Судлаач Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д:

1. “Хөөмий тагнайн уг, хөөмийн гүн, (тагнайн угт хөнтрөн ургасан мах), хөөмийдөх (хөөмийгөөр дуугарах), хөөмийлөх (хөөмийгөөр дуу аялах).
2. Нарийн үст амьтны өөхийн дагуу арьсны өнгө төсөөтэй хэсэг хувь газар (булга, үнэг, тасын хөөмий), хөөмийлөх-нарийн үст амьтны хөөмийн хэсгийг авах (булганы арьс хөөмийлөх)” (Цэвэл, 1966, х.713) гэж тэмдэглэжээ.

Өвөр Монголын судлаач Цэцэнцогт (kugem-e) хогом 1. “төвөнхийн дотор тал”-ын гүн, гийгүүлэгч, 2. өөхийн дагуу хэсэг мөн хөгөмэ гэж булга, үнэг зэргийн эрүүний доорх хөөмийн орчны үс арьс (Цэцэнцогт, 1988, х.1161) гэсэн бол эрдэмтэн Рашдонров “Хөөмий нь амны хөндийн хойд хэсэг дэх булчин ба шүлт бүрхэвчээр бүрэлдсэн гуурс, амьсгалах болон хоолойн хөндийн залгих зам мөн болой. Хөөмий нь амны хөндийд саадгүйгээр дуу авиа гаргах гэсэн үг бөгөөд үндсэнд нь 3 ангилан үздэг. Дээд хэсэгт хамрын хөндийн хэсэг, дунд хэсэгт амны хөндийн хэсэг, доод хэсэгт төвөнхийн ар хэсэг гэж ангилна” (Рашдонров, 1988, х.60) гэсэн байна.

Ардын урлаг судлаач Ж.Бадраа “Монгол ардын хөгжмийн өгүүлэхийн эрхтэнтэй шүтэлцэх урлагт: аялан исгэрэх урлаг, амаар таших дэлдэх урлаг, хөөмэйлэх урлаг, цуурдах урлаг, аман хуурын урлаг эдгээр таван зүйлийн урлагийг хамруулан хэлэлцэж болно. Өгүүлэхийн эрхтэнтэй шүтэлцэх гэдгийн учир бол “хөгжим үүсгэх” гэж монголчуудын хэлдэг хөгжмийн эгшгийг дуурьсгах арга зүйн хувьд хүний өгүүлэхийн эрхтэн хөгжмийн зэмсгийн үүрэг гүйцэтгэх юмуу эсхүл өгүүлэхийн

эрхтэн хөгжмийн зэмсэгтэй хавсран нэгдэж, тэрхүү зэмсгийн ямар нэгэн эд анги болдогт байгаа юм” (Бадраа, 1998, х.41) хэмээн өгүүлэх эрхтэнтэй шүтэлцэх урлагийн онцлогийг тодорхойлсон байна. Харин хөөмийн тухайд “Хөөмэйлэх гэдэг бол хэлнийхээ үзүүр үүдэн шүдээр гоё хөөрхөн нугалаа чимэгтэй ая исгэрэхийн чацуу хөөмэйнхээ гүнд үргэлжлэн хүнгэнэсэн дэвсгэр эгшиг дуурьсгахын нэр юм” (Бадраа, 1998, х.46) гэжээ.

Хөөмийн төрөл зүйлийг хөөмийчид болон хөөмийн урлаг судлаачдын ихэнх нь 2-3, 4, 5, 6 төрөлд хуваан авч үзэж байхад зарим нь түүнээс дээш 7, 12 төрөл гэхчилэн янз янзаар ангилан, нэрлэсээр ирсэн байна.

БНХАУ болон ОХУ-д амьдардаг монгол туургатнууд хөөмийг уламжлан хөгжүүлэхдээ өөр өөр янзаар ангилсан байдаг. Тухайлбал, Өвөр Монголын боржигончуудын хөөмийлэх онцлог нь хөөмий төст бахлуурын авиа барьдаг хэлбэр нь уламжлан үлджээ. Тиймээс хөөмийг цоорын дуу, бахлуурын дуу ч гэж нэрлэдэг. Тэгвэл Тува улсад хөөмийг:

1. Сыгыт
2. Хөөмий
3. Каргыраа
4. Барбыцнадыр
5. Эзынглээр гэж таван төрөл зүйлд хуваан үздэг. (Цэдэн-иш, 2009, х. 113)

Харин хөөмийч Д.Цэрэндаваа, Н.Сэнгэдорж нар хөөмийг 8 төрөл ангилалд хуваажээ.

1. Авиа гаргах дасгал
2. Харгилах, хархираа
3. Уруулын
4. Тагнайн
5. Хамрын
6. Багалзуурын
7. Цээжний
8. Хосмолжин хэмээн ангилжээ (Хэрлэн, 2010, х.114).

Монгол улсын хөөмийч, МУУГЗ Б.Одсүрэн хөөмийг дараах 12 ангилалд хуваан үзсэн талаар дурдсан байдаг. Үүнд:

1. Цуур шулуун хөөмий
2. Цуурайтай исгэрээ хөөмий
3. Үелзсэн цуур хөөмий
4. Шулуун хархираа хөөмий
5. Исгэрээтэй хархираа хөөмий
6. Туулийн хархираа хөөмий
7. Гиргирээ (харгиа) хөөмий
8. Хамрын хөөмий
9. Шулуун исгэрээ хөөмий
10. Нарийн исгэрээ хөөмий
11. Уруулын хөөмий
12. Дандалдах хөөмий (Баянжаргал, 2006, х.193-194) гэх зэргээр ангилжээ.

Бидний үзэж байгаагаар одоогоор хамгийн голчлон хэрэглэж, ашиглаж нэршиж

заншсан үндсэн зургаан төрөл зүйлийг ангилан, авч үзэж болохоор байна. Үүнд:

1. Исгэрээ хөөмий /шингэн, нарийн/
2. Шахаа хөөмий /багалзуурын/
3. Хосмолжин хөөмий /магтаал хэлэхтэй хослох/
4. Хархираа хөөмий /цээжний хөөмий/
5. **Цуур** хөөмий /харгиа хөөмий/
6. Хамрын хөөмий зэрэг болно.

## **Үндсэн хэсэг 2. Монгол хөөмийн сургалтын уламжлал, шинэчлэл**

Ардын билэг зүйч, хөгжим, урлаг судлаач, МУУГЗ Ж.Бадраагийн бүтээл “Монгол хөөмий” (1982) баримтад кинонд “...Чандмань нутгийнхан хөөмийн урлагийг бүхнээс эрхэмлэн дээдэлж, хөгшин, залуу, хөрөв нялхгүй хөөмийлж байна” хэмээн өгүүлдэг.

Хөгжим судлаач Ж.Энэбиш “...орчин үеийн монголын хөөмийчид хөөмийн урлагийг үндсэн хоёр хэлбэрээр сурч эзэмшиж байна. Үүнд нэгдүгээрт, ах дүү, үр хүүхэд, ач гуч нараас уламжлан сурч, улмаар мэргэжлийн урлагийн театр, чуулгуудын тайзнаа алдаршиж байна. Хоёрдугаарт, тусгай хөтөлбөрийн дагуу албан ёсны сургалтаар сурч байна” (Энэбиш, 2008, х.107) хэмээн хөөмий сургалтын үндсэн хоёр арга замыг тодорхойлсон байна.

Түүний бичсэнээр “...Ховдын хязгаар нутаг, алтайн урианхайчуудын дунд уламжлалт хөөмий, модон цуурын урлаг түгээмэл дэлгэрсэн байжээ. Хөрш зэргэлдээ нутаглах урианхайчуудаас хөөмий сурч, Чандмань сумын залуучуудад зааж дэлгэрүүлсэн хүн бол тус сумын 6-р багийн малчин Тогоочийн Дэрэм (1893-1966), Тогоочийн Чулуун (1896-1968) ах дүү хоёр юм. Дэрэмийн хуучилснаар бол тэрбээр Хатанбаатарын цэргийг Цагаан дэрс гэдэг газарт байрлаж байхад нь цэргийн унаа хүргэх ажлаар явах замдаа урианхайчуудаас анх хөөмийг сонсож сурсан ажээ. Дэрэм бас модон цуур тагдаг байжээ. Чулуун бол Дэрэм ахаасаа хөөмий сурч, улмаар нутаг усандаа дэлгэрүүлсэн хүн юм байна” (Энэбиш, 2008, х.105-106) гэснээс үзвэл, хөөмийг сурах нь тухайн хүний сонирхол, авьяас чадвараас хамаарч, богино хугацаанд ч сурах боломжтойг илтгэж байна.

Монгол хөөмийн сургалтыг хөгжүүлэх үүднээс Ж.Бадраа 1980-аад оноос эхлэн Улаанбаатарт Д.Цэрэндаваа, Т.Ганболд нартай хамтран сургалт зохион байгуулах анхны оролдлого хийж эхэлсэн ба 1990-ээд оны эхнээс хөөмийг Б.Одсүрэнгээр дээд боловсролын тогтолцоогоор дамжуулан сургах том ажлыг эхлүүлсэн байна. Өрнөл ихтэй ийм үед, Чандманийн болон Алтайн нурууны бусад орон нутгийн хөөмийчид хөөмийг заах нарийн арга барил боловсруулж эхэлсэн ба аман уламжлалын жинхэнэ “дэг сургууль” үндэслэсэн нь өнөөдөр хөөмийн хүрээнийхний дунд Д.Цэрэндаваа, Р.Даваажав, Улаангомын Тойвгоо, Цэнгэлийн зэргээр танигдсан байна.

Хөөмийн урлаг нь өөрийн гэсэн уламжлалт сургалтаар үеэс үед дамжин ирсээр эдүгээ орчин үеийн системтэй сургалтад шилжин гүнзгийрч, хамрах хүрээ нь өргөжих хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, уламжлалт буюу гэрийн сургалтын хэлбэрээр хөөмийг сурахаас гадна дунд сургуулийн дуу хөгжмийн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад хөөмийн тухай тодорхой мэдлэг ойлголтыг

өгч байгаа бол мэргэжлийн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хөөмийн сургалтын агуулга, арга зүйг тусган хэрэгжүүлж байгаа нь хөөмий нь өөрийн гэсэн тодорхой дэг сургуультай болж, өргөжин хөгжиж байгаагийн тод илрэл юм.

Хөгжим судлаач Д.Пүрэвсүрэн ардын дуу хуурын төрөл зүйлийг хөгжмийн боловсролын үүднээс “хүний уриа дуудлага, малын уриа дуудлага, хуурдан аялж хэлэх төрөл, өгүүлэх эрхтний, аялгат тоглоом” (Пүрэвсүрэн, 2007, х.10) хэмээн ангилж, өгүүлэх эрхтний төрөлд хөөмий, шүд уруулын исгэрээ, аман ташлага, шахам эгшиг зэргийг багтаасан байна. Мөн тэрээр “Өгүүлэхийн эрхтний хамааралтай хөөмий, исгэрээнүүд аман ташлага зэрэг нь хоолой амны хийн тусламжтайгаар ая эгшиг үүсгэдэг... Хөөмий, исгэрээ, аман ташлага нь нэг ёсны хөгжмийн үүргийг гүйцэтгэдэг” (Пүрэвсүрэн, 2007, х.12) хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын “Дунд сургуулийн сургалтын төлөвлөгөө” (2019)-д тусгагдсан VII ангийн “Хөгжим” хичээлийн агуулгад “Өгүүлэх эрхтний шүтэлцээт урлаг хөөмийн төрлүүдийг (исгэрээ, шахаа, хархираа) сонсож, таних, тодорхойлох” (БСШУСЯ, 2019, х.108) гэсэн агуулгыг тусгажээ. Уг агуулга сурах бичигт хэрхэн туссаныг үзвэл, Хөгжим VI-VII сурах бичгийн 73-78-р хуудсанд “Монгол ардын дуу хөгжмийн төрлүүд”, “Өгүүлэх эрхтэнтэй шүтэлцэх урлаг: Исгэрээ, Хөөмий”, “Дөрвөн уул” монгол ардын дууг хөөмийлснөөс сонсох, Төрийн соёрхолт, хөгжмийн зохиолч Ц.Нацагдоржийн “Хөөмий, морин хуур, симфони найрал хөгжмийн концерт” (Оюунбилэг, Ариунаа, Ариунчимэг, Ууганцэцэг, 2017, х.73-78) бүтээлийн тухай тусгасан нь хөгжмийн боловсролын үүднээс хөөмийг судлах хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Цаашид хөөмийн урлагийн талаар ном, сурах бичигт тусгахаас гадна интернэт цахим эх сурвалж, хэрэглэгдэхүүнийг ашиглан, энэхүү гайхамшигт урлагийг хүүхэд залуусд сурталчлан таниулах өргөн боломжтой хэмээн үзэж байна. Энэ талаар гадаадын зарим улс оронд онлайн сургалтын янз бүрийн хэлбэрүүд ч үүсч хөгжиж байгаа юм.

Тухайлбал, ОХУ-ын цахим интернэтэд “Хөөмийг хэрхэн сурах” (Как научиться горловому пению), Хөөмийг хэрхэн бие даан сурах (Как самостоятельно научиться горловому пению) тухай төрөл бүрийн хайлт, видео дүрс бичлэгүүд цөөнгүй байна. ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсын хөөмийчин, “Азийн дуу хоолой” уралдааны гурван удаагийн шагналт Александр Куулар хэмээх залуу “Байгалийн дуу хоолой” хэмээх нэртэй хөөмийн онлайн сургуулийг хичээлүүлэн, дэлхийн өнцөг булан бүрээс 3000 гаруй сурагчдыг тус онлайн курсээр (<https://throatsingingcourse.getcourse.ru/rus>) амжилттай сургасан байна.

## Судалгааны үр дүн

Монгол улсын “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр”-ийн “Урлаг” хичээлийн агуулгаар “Сурагч нь аливаа юмс, үзэгдэл, урлагийн бүтээлийг судлах бүтээлч эрэлхийллийн арга барилтай, өөрийн авьяас, гоо сайхны мэдрэмжээ илэрхийлж, хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй, урлаг соёлыг эрхэмлэдэг иргэн болж төлөвшинө” (БСШУСЯ, 2019, х.107) гэсэн зорилгыг тодорхойлж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид нь мэдэрч ойлгох, сонирхон судлах, бүтээж хөгжүүлэх, илэрхийлэх үнэлэх

зэрэг чадвар эзэмшинэ хэмээн тусгажээ.

Монгол ардын хөгжмийн өгүүлэхийн эрхтэнтэй шүтэлцэх урлагийн тухай өгүүлсэн судлаачдын бүтээлүүдэд “...хүн байгалийн элдэв дуу чимээг бишрэн гайхсны улмаас даган дуурайхад шилжсэн нь хөгжим үүсгэх нөхцөл шалтгаан болсон” (Бадраа, 1998, х.42) зэргээс үзвэл Монголчуудын уламжлалт исгэрээ, хөөмийн төрлүүдийг хүүхэд залууст сурталчлан таниулах нь дээрх зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, чадваруудыг эзэмшүүлэх нэгэн алхам гэж үзэж байна.

## Дүгнэлт

Өгүүлэх эрхтэнтэй шүтэлцэх урлагийн төрөл болох исгэрээ, хөөмийг зөвхөн хөгжмийн онол, арга зүйн үүднээс дунд сургуулийн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулгад тусгах төдий бус уг урлагийн уран сайхныг мэдэрч ойлгох, дүр, дүрслэлийн талаар таамаглах, эргэцүүлэх, агуулгыг нь мэдэрч, гоо сайхны мэдрэмж, таашаалаа хөгжүүлэх агуулгыг эзэмшүүлэхэд сургалтын бусад орчин хэрэглэгдэхүүнийг уламжлалт болон орчин үеийн хөгжмийн сургалтын шаардлагатай уялдуулан хөгжүүлэх нь зүйтэй байна.

## Ном зүй

Бадраа, Ж. (1982). Монгол хөөмий баримтат кино. Улаанбаатар: Кино үйлдвэр.

Бадраа, Ж. (1998). Монгол ардын хөгжим. Улаанбаатар. Хэвлэх үйлдвэр.

Баянжаргал, С. (2006). Цоорын дуу болон хоолойн цоор. Хонг Конг: Тиан Ма үйлдвэр.

БСШУСЯ. (2019). Суурь боловсролын сургалтын хөтөлбөр. (Сайжруулсан хоёр дахь хэвлэл).

Горловое пение онлайн курс. <https://throatsingingcourse.getcourse.ru/rus>

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг. (2006). Монгол хөөмийн урлагийг хөгжүүлэх тухай.

Пүрэвсүрэн, Д. (2007). Монголын хөгжмийн боловсролын уламжлал, шинэчлэл. Улаанбаатар: Содпресс.

Рашдонров. (1988). Сурагчийн монгол хэлний толь. Хөх хот.

Хэрлэн, Л. (2010). Монгол хөөмийн утга холбогдол. Улаанбаатар: Удам соёл.

Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.

Цэдэн-Иш, А. (2009). Хөгжил. Улаанбаатар: Жиком Пресс.

Цэдэн-Иш, А. (2009). Хөгжим. Улаанбаатар: Жиком Пресс.

Цэцэнцогт. (1988). Монгол үгсийн язгуурын толь. Хөх хот: Өвөр монголын хэвлэлийн хороо.

Энэбиш, Ж. (2008). Монгол хөгжим судлалын дээж бичиг. Улаанбаатар: Соёмбо принтер.

## **THE NEEDS AND REQUIREMENTS OF STUDYING MONGOLIAN ART OF SINGING KHOOMEI FROM THE POINT OF VIEW OF MUSIC EDUCATION**

<sup>a</sup>Burigede

<sup>a</sup>China, Inner Mongolia, master

Corresponding author: burigedebaatar@gmail.com 

### **Abstract**

The “khoomei” or throat singing is an ancestral overtone singing that consists in reproducing natural sounds like the flow of water, the breath of wind, the echo of the mountains, the rumble of thunder, the singing of birds, etc. An overtone singing is characterised by a vocal technique that allows to make simultaneously several sounds with a single vocal organ, combining different voices and different ways to place the tongue or the lips. Khoomei is said to come from the area of Khovd, in the Altai range, western Mongolia.

### **Keywords**

Throat singing, style of Khoomei, harmony of multiple voice parts

---